

Улсын тусгай хэрэгцээний газрын ойд ойн аж ахуйн арга хэмжээ явуулах журам

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 05 дугаар сарын 01-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А-134

Журам батлах тухай

Ойн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улсын тусгай хэрэгцээний газрын ойд ойн аж ахуйн арга хэмжээ явуулах журам" -ыг хавсралтын ёсоор баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Гантулга /-т үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А-203 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

САЙД

С.ОЮУН

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын

2013 оны 05 сарын 01-ны өдрийн

А-134 дугаар тушаалын хавсралт

УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН ОЙД ОЙН

АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭ ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь улсын тусгай хэрэгцээний газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Улсын тусгай хэрэгцээний газрын ой гэдэгт Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан газрын ой хамаарна.

1.3. Улсын тусгай хэрэгцээний газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээнд дараах үйл ажиллагааг хамааруулна:

1.3.1. ойд ажиглалт судалгаа явуулах;

1.3.2. ойн тооллого, зохион байгуулалтын ажил гүйцэтгэх;

1.3.3. ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;

1.3.4. ойд хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх;

1.3.5. ойд нөхөн сэргээх, үржүүлэх;

1.3.6. ойд, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах;

1.3.7. ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэгдсэн бусад үйл ажиллагаа.

1.4. Улсын тусгай хэрэгцээний газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг ойн тооллого, зохион байгуулалтын ажлын тайлан материалд тулгуурлан, ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж шаардагдах зардлыг тусгай хэрэгцээний газрыг эзэмшигч, ашиглагч болон тусгай хамгаалалттай газрын захиргаа нь тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

1.5. Улсын тусгай хэрэгцээний газрын менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч зайлшгүй хийх шаардлагатай ойн түймрээс хамгаалах, хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх арга хэмжээг тухай бүр энэ журамд зааснаар, шаардлагатай бол зохих шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлнэ.

1.6. Ойн аж ахуйн арга хэмжээг явуулахдаа батлагдсан журам, технологийн заавар, норм, нормативыг удирдлага болгоно.

1.7 Тусгай хэрэгцээний газрын ойд мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах эрхийн бичиг, өөр аймаг сум, хот суурингийн хооронд тээвэрлэх, худалдах бол гарал үүслийн

гэрчилгээ авах, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх талаар гэрээ байгуулах, гүйцэтгэлийг тайлагнах ажлыг холбогдох журмын дагуу гүйцэтгэнэ.

1.8. Түймрээс хамгаалах халз зурвас, харуулын өндөрлөг байгуулах, эргүүл харуул зохион байгуулах, мод сөөгний үр, мөчир түүж бэлтгэх, ойн хөрс, усны элэгдэл, элсний нүүдлээс хамгаалах зэрэг ойн аж ахуйн арга хэмжээг тухайн улсын тусгай хэрэгцээний газрыг эзэмшигч, ашиглагч хэрэгжүүлнэ.

1.9. Энэ журмын 1.8-д зааснаас бусад тохиолдолд улсын тусгай хэрэгцээний газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшсэн ойн нөхөрлөл, төрийн болон ойн судалгаа шинжилгээний байгууллагууд тухайн улсын тусгай хэрэгцээний газрыг эзэмшигч, ашиглагчтай хамтран болон дангаараа энэ журмын хоёр болон гуравдугаар зүйлд заасан дэглэмийг мөрдөж ажиллана.

Хоёр. Тусгай хамгаалалттай газар нутгийн ойд ойн аж ахуйн арга хэмжээ явуулах дэглэм

2.1. Тусгай хамгаалалттай газрын ойн санд ой зохион байгуулалтын ажлыг тусгайлан хийсэн байна.

2.2. Тусгай хамгаалалттай газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг зөвшөөрөгдөх бүсүүдэд тухайн тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөнд тусган байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан байна.

2.3. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь ойн аж ахуйн арга хэмжээг ойн тооллого, зохион байгуулалтын тайлан материал, менежментийн төлөвлөгөөг үндэслэн ойн мэргэжлийн байгууллагын санал дүгнэлт, зөвлөмжийн дагуу нэг жилээр төлөвлөж, шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвтөө тусгана.

2.4. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь менежментийн төлөвлөгөөнд тусгасан ойн аж ахуйн арга хэмжээг явуулахдаа энэ журмын 2.5, 2.6-д заасны дагуу холбогдох шийдвэр гаргуулж, тухайн төрлийн ойн аж ахуйн арга хэмжээг явуулахад шаардагдах зураг, төслийг ажил эхлэхийн өмнө боловсруулж, баталгаажуулсан байна.

2.5. Энэ журмын 1.8-д заасан болон ойн үрийн байнгын талбай байгуулах, сор болон шилмэл модыг сонгон тусгаарлах ойн аж ахуйн арга хэмжээ явуулах шийдвэрийг тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа гаргаж, төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

2.6. Энэ журмын 2.5-д зааснаас бусад ойн аж ахуйн арга хэмжээ явуулах шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

2.7. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь энэ журмын 2.6-д заасан шийдвэрийг үндэслэн Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын тухай хуулийн дагуу ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүдийн дунд зарлаж, шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж, гүйцэтгэлийг нь хүлээн авч, үр дүнгийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

2.8. Гүйцэтгэгч нь хууль тогтоомжийг зөрчих буюу энэ журмын 2.4-д заасны дагуу баталгаажуулсан зураг, төсөлд заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээг цуцлах үндэслэл болно.

2.9. Тусгай хамгаалалттай газрын ойн аж ахуйн арга хэмжээг холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөл, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан арга зүй, ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

2.10. Тусгай хамгаалалттай газрын ойд ойн аж ахуйн арга хэмжээг түүний хамгаалалтын горимд нийцүүлж явуулна.

2.11. Тусгай хамгаалалтын газар нутгийн ойд ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ мод, ургамал цэцэглэх, ан амьтны орооны болон төллөхөөс бусад үед хийнэ.

Гурав. Улсын тусгай хэрэгцээний бусад газрын ойд ойн аж ахуйн арга хэмжээ явуулах дэглэм

3.1. Улсын хилийн зурвас газрын ойд явуулах ойд **явуулах ойн аж ахуйн арга хэмжээг хил хамгаалах байгууллагын зөвшөөрлөөр** явуулна. Ингэхдээ "Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай" Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээ, "Монгол-Хятадын хилийн дэглэмийн тухай" Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ, Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2008 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/21 тоот тушаал болон цаашид түүнийг шинэчлэн гарах эрх зүйн актаар батлагдсан "Хилийн бүс, зурваст үйл ажиллагаа явуулах, зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ыг баримтална.

3.2. Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр явуулна.

3.3. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдсэний үндсэн дээр хэрэгжүүлэх бөгөөд уг арга хэмжээний үр дүнгийн тайланг мөн байгууллагад хүргүүлнэ.

3.4. Ойн эрдэм шинжилгээ судалгаа, сургалтын байгууллага нь шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчны төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрөл, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан урт хугацааны судалгаа шинжилгээний ажлын төлөвлөгөөнд үндэслэн хэрэгжүүлнэ.

3.5. Ойн эрдэм шинжилгээ судалгаа, сургалтын байгууллага нь шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчны төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг өөрийн хүчээр хэрэгжүүлэх боломжгүй бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүдийн дунд сонгон шалгаруулалт зарлан гүйцэтгүүлж болно.

3.6. Цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг ус цаг уур, орчны шинжилгээний байгууллагатай зөвшилцөн гүйцэтгэнэ.

3.7. Аймаг дундын отрын бэлчээр, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай, бичил уурхайн зориулалтаар олгосон газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг харьяалах аймгийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусган, Ойн тухай хууль болон энэ журамд зааснаар хэрэгжүүлнэ.

3.8. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбайн ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 37, 38, 39 дүгээр зүйлд заасан журмаар менежментийн төлөвлөгөөндөө тусган өөрийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ.

3.9. Чөлөөт бүсийн газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг Чөлөөт бүсийн тухай хуулийн 12.1.5-д заасны дагуу чөлөөт бүсийн захирагч нь тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргатай хамтран ажиллах хүрээнд харьяалах аймгийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу хэрэгжүүлнэ.

3.10. Цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр явуулж, Онцгой байдлын ерөнхий газарт мэдэгдэнэ.

3.11. Бичил уурхайд үйл ажиллагаа явуулдаг иргэдийн нөхөрлөл нь ойн менежментийн төлөвлөгөөнд туссаны дагуу ойн аж ахуйн арга хэмжээг жил бүр хэрэгжүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Ойн нөөц бүхий улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд ойн мэргэжилтэн ажиллуулна.

4.2. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагчид ойн аж ахуйн арга хэмжээний талаарх сургалтанд хамрагдсан байна.

4.3. Ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлсэн Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, улсын тусгай хэрэгцээний газрыг эзэмшигч, ашиглагч уг арга хэмжээг гүйцэтгэсэн ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөл нь ойн аж ахуйн арга хэмжээний гүйцэтгэл бүрийн тайлан, холбогдох акт баримтыг бүрдүүлж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, тухайн оны мэдээ тайланд тусгуулна.

4.4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын хэмжээнд явуулсан ойн аж ахуйн арга хэмжээний үр дүнгийн судалгааг 2 жил тутам хийж, дүгнэлт гарган, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

4.5. Ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлсний дүнд олсон орлогыг Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, улсын тусгай хэрэгцээний газрыг эзэмшигч, ашиглагч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон биотехникийн арга хэмжээнд зохих журмын дагуу зарцуулж болно.

4.6. Арчилгаа, цэвэрлэгээ хийх модны хэмжээг хэтрүүлэн олгосон Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга, эрх бүхий албан тушаалтанд Ойн тухай хуулийн 47.2.8-д зааснаар, арчилгаа цэвэрлэгээний хэмжээг хэтрүүлсэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад Ойн тухай хуулийн 47.2.5-д зааснаар тус тус захиргааны арга хэмжээ авч, дараа жилд явуулах арчилгаа, цэвэрлэгээний ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалтад оролцуулахгүй байх саналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

-----oOo-----